

МОНГОЛ УЛС

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2006 оны 09 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

“Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс тогтоох журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тооцох аргачлалыг хавсралтаар баталсугай.

2. Аргачлалын дагуу санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдээс зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тооцон, төвлөрүүлж ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧЭЭС ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар баталсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс тогтоох журам”-аар /цаашид “Журам” гэх/ тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага нь жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох дансанд төвлөрүүлэхээр журамласан.

Энэхүү хөлсний хэмжээ нь тухайн байгууллагын санхүүгийн зах зээл дээр эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлээс хамаарч актив хөрөнгө болон дүрмийн сан, татан төвлөрүүлсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгө, гаргасан нийт үнэт цаасны нэрлэсэн үнийн дүн зэргээс тооцоологдоно. Түүнчлэн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчилгээний төрлөөс хамааран зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ хэлбэлзэнэ.

Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тооцоолох аргачлалыг салбар тус бүрээр үзүүлбэл:

НЭГ. Банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/.

ББСБ-ын зохицуулалтын үйлчилгээний хөлсийг түүний актив хөрөнгөөс тооцно. Актив хөрөнгийн хэмжээг нийт 7 ангилалд хуваасан бөгөөд ангилал тус бүрт харгалзах хувийг Журмын 1 дүгээр хавсралтын 1 дүгээр хүснэгтээр тогтоож өгсөн.

Үйлчилгээний төрөл бүрт ногдох хувийг дараах байдлаар тогтоосон. Үүнд:

1/зээлийн үйл ажиллагаа	* 0.1 %
2/факторинги	* 0.2 %
3/төлбөрийн баталгаа гаргах	* 0.2 %
4/гадаад валютын арилжаа	*0.05 %
5/хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	* 0.15 %
6/төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	* 0.2 %
7/цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга	* 0.3 %
8/богино хугацааны санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	* 0.01 %
9/итгэлцлийн үйлчилгээ	* 0.5 %

Актив хөрөнгийн ангилал бүрт ногдох хувийг дараах байдлаар тогтоосон. Үүнд:

>10,0	10,0 - 25,0	25,0 - 50,0	50,0 – 100,0	100,0 - 500,0	500,0 - 1.000,0	1.000,0>
200,0%	150,0%	100,0%	50,0%	200,0%	150,0%	100,0%

Жишээ 1: “А” ББСБ-ыг 200.0 сая төгрөгийн актив хөрөнгөтэй, 9 төрлийн үйлчилгээ үзүүлдэг гэвэл үйлчилгээний төрөл бүрт ногдох хувь хэмжээний дагуу нийт 3 420 000 төгрөг тооцоологдож байна. Гэтэл “А” ББСБ нь 100 000 000 - 500 000 000 төгрөгийн актив хөрөнгөтэй байгууллагын ангилалд багтаж байгаа тул тооцоологдсон 3 420 000 төгрөгийг 200 хувиар буюу 2 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр хөлс төлөх учиртай. Иймээс “А” ББСБ-ын зохицуулалтын үйлчилгээнд төлөх бодит хөлсний хэмжээ нь 6 840 000 төгрөг болно.

Хэрвээ “А” ББСБ нь зөвхөн зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг бол дээрх тооцооллуудын дагуу зохицуулалтын хөлсөнд 400 000 төгрөгийг төлөх учиртай.

Жишээ 2: “Б” ББСБ-ыг 1.0 тэрбум төгрөгийн актив хөрөнгөтэй, 9 төрлийн үйлчилгээ үзүүлдэг гэвэл үйлчилгээний төрөл бүрт ногдох хувь хэмжээний дагуу нийт 17 100 000 төгрөг тооцоологдож байна. “Б” ББСБ нь 1.0 тэрбум төгрөгийн актив хөрөнгөтэй байгууллагын ангилалд багтаж байгаа тул тооцоологдсон 17 100 000 төгрөгийг төлнө.

Хэрвээ “Б” ББСБ зөвхөн зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг бол тухайн үйлчилгээнд ногдох хувиар буюу 1 000 000 төгрөг төлнө.

ХОЁР. Даатгалын компани.

Даатгалын компанийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг түүний дүрмийн сангаас тооцно. Үйлчилгээний төрөл тус бүрт харгалзах хувь хэмжээ болон мөнгөн дүнг Журмын 2А, 2Б хавсралтаар тогтоож өгсөн.

Жишээ: Доорх 5 төрлийн үйлчилгээ үзүүлдэг, 1,5 тэрбум төгрөгийн дүрмийн сантай “В” даатгалын компанийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг дараах байдлаар тооцно. Үүнд:

- 1/хөрөнгийн даатгалын үйл ажиллагаа * 0.1 % буюу 1 500 000 төгрөг;
- 2/иргэний агаарын хөлгийн даатгалын үйл ажиллагаа 500 000 төгрөг;
- 3/газрын тосны даатгалын үйл ажиллагаа 500 000 төгрөг;
- 4/гаднаас авах давхар даатгалын үйл ажиллагаа * 0.2% буюу 3 000 000 төгрөг;
- 5/Агаарын хөлгийн их бие, түүний өмч болон эзэмшигч хариуцлагын даатгалын үйл ажиллагаа 600 000 төгрөг; /гэх мэт/

Энэ тооцооллын дагуу “В” даатгалын компани нь нийт 6,1 сая төгрөг төлөх учиртай.

ГУРАВ. Үнэт цаас гаргагч, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага.

3.1 Хөрөнгийн бирж, үнэт цаасны төлбөр тооцоо, үнэт цаасны хадгаламж, брокер, дилер, андеррайтерийн зэрэг үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн оролцогчид нь

Журмын 3 дугаар хавсралтад заасны дагуу тусгай зөвшөөрөл авсан үйлчилгээний төрөл бүрт ногдох мөнгөн дүнгээр зохицуулалтын үйлчилгээний хөлс төлнө.

Жишээ: “Г” ХК брокер дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан гэвэл тооцооллын дагуу нийт 2.0 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлс төлнө.

3.2 Үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхэлж буй үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд бүтгэгдсэн үнэт цаас гаргагчид нь гаргасан нийт үнэт цаасныхаа нэрлэсэн үнийн дүнгээс 0.035 хувиар тооцож зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төлөхөөр Журмын 3 дугаар хавсралтын 2 дугаар хүснэгтээр тогтоож өгсөн.

Жишээ: “Д” ХК-ийн нийт гаргасан хувьцаа 2.0 сая төгрөг бөгөөд нэрлэсэн үнэ нь 150 төгрөг гэвэл тооцооллын дагуу 105 000 төгрөг төлнө.

ДӨРӨВ. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг хоршоо.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг хоршооны зохицуулалтын үйлчилгээний хөлсийг түүний татан төвлөрүүлсэн хөрөнгийнх нь дүнгээс тооцно. Зохицуулалтын үйлчилгээний хөлсний доод хэмжээг 15 000 төгрөг байхаар Журмын 4 дүгээр хавсралтаар тогтоож өгсөн.

Жишээ 1: “Е” хадгаламж зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг хоршоо нь гишүүдээсээ 1.0 тэрбум төгрөгийн хадгаламж төвлөрүүлсэн гэвэл 0.05% хувиар тооцож 500 000 төгрөгийг төлнө.

Жишээ 2: “Ё” хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг хоршоо нь гишүүдээсээ 9 000 000 төгрөгийн хадгаламж төвлөрүүлсэн гэвэл дээрх тооцооллын дагуу 4 500 төгрөгийг төлөхөөр байгаа хэдий ч зохицуулалтын үйлчилгээний хөлсний доод хэмжээ болох 15 000 төгрөгийг төлнө.

ТАВ. Валют солих цэг.

Валют солих цэгийн үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг нийт эргэлтийн хөрөнгөөс тооцно.

Жишээ: “Ж” Валют солих цэг нь 20 000 000 төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй гэж үзвэл 0.1 хувь буюу 20 000 төгрөгийг төлнө.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО